

ОЮУНЫ ӨМЧИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар “Оюуны өмчийн шилдэг бүтээл” шагналд нэр дэвшүүлэх болон гардуулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Оюуны өмчийн шилдэг бүтээлд аж үйлдвэрийн өмчид хамаарах шинэ бүтээл, барааны тэмдэг, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар болон зохиогчийн эрхийн бүтээлүүдийг хамруулна.

ХОЁР. НЭР ДЭВШҮҮЛЭХ, ШАЛГАРУУЛАХ

2.1. “Оюуны өмчийн шилдэг бүтээл”-ээр дор дурдсан шаардлага хангасан бүтээлийг шалгаруулна.

2.1.1. Монгол улс, олон улсад эрхийн хамгаалалт хийгдэж патент, гэрчилгээ авч, зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг бусад оронд сурталчлан таниулах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж, төр, нийгэм, үндэстний өмнө онцгой гавьяа байгуулсан, Монгол Улсын эдийн засгийн эргэлтэд орж ашиг орлого олсон байдал, гадаад улсад экспортолсон байдал, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн иргэн хуулийн этгээдийн бүтээл.

2.2. “Оюуны өмчийн шилдэг бүтээл” шагналыг жилд нэг удаа 2.1.1 дэх хэсэгт заасан шаардлага хангасан бүтээлд олгоно.

2.3. Оюуны өмчийн бүтээл зохион бүтээж, туурвисан зохион бүтээгч, шинийг санаачлагч, уран бүтээлч, эрх эзэмшигч “Оюуны өмчийн шилдэг бүтээл шагнал”-д өөрсдийн бүтээлийг нэр дэвшүүлнэ.

2.4. “Оюуны өмчийн шилдэг бүтээл” шагналд бүтээлд нэр дэвшүүлэх хүсэлтийг Оюуны өмчийн газарт тухайн жилийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор доорх бүрдлийг хангаж ирүүлнэ.

2.4.1. Бүтээл, түүний товч танилцуулга, тодорхойлолт;

2.4.2. Бүтээлийн онолын түвшин, шинжлэх ухааны ач холбогдлын талаар 2-оос доошгүй эрдэмтэн, уран бүтээлчийн дүгнэлт, /дүгнэлт гаргасан эрдэмтэн ямар нэг хэлбэрээр хамтран зохиогч байж болохгүй/;

2.4.3. Бүтээлийг үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын үнэлэлт, дүгнэлт, холбогдох баримт бичиг;

2.4.4. Эрхийн хамгаалалт хийгдсэн бүтээлийн гэрчилгээ, патентын хуулбар;

2.4.5. Зохиогчийн анкет, ажил байдлын тодорхойлолт, бүтээлийн жагсаалт;

2.4.6. Монгол улсын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан тухай судалгаа, тайлан;

2.4.7. Гадаад улсад экспортлосон эсхүл импорт орлох бүтээгдэхүүнийг нотлох баримт бичиг;

2.4.8 Нэр дэвшүүлж буй бүтээлээ нийтэд таниулан сурталчилсан талаарх судалгаа.

2.5. Нэр дэвшүүлэхээр ирүүлсэн бүтээлийн материалыг нэр дэвшүүлэгчид буцаан олгохгүй.

2.6. Нэр дэвшүүлэхээр ирүүлсэн материалыг дараах тохиолдолд шалгаруулалтад оролцуулахгүй.

2.6.1. материалын бүрдүүлбэр 2.4 дэх хэсэгт заагдсан шаардлага хангаагүй, дутуу бүрдүүлсэн;

2.6.2. материалын бүрдүүлбэрийг хуурамчаар бүрдүүлсэн;

2.6.3. хүсэлтийг журамд заасан хугацаанд ирүүлээгүй.

2.7. Нэр дэвшүүлэгч бүтээлээ шалгаруулалтын шийдвэр гарахаас өмнө аль ч шатанд хүсэлтээ эргүүлэн татаж болно.

2.8. Тухайн жилд энэ журмын шаардлага хангасан бүтээл нэр дэвшээгүй тохиолдолд Оюуны өмчийн шилдэг бүтээл шагналыг олгохгүй.

ГУРАВ. ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙГ ШАЛГАРУУЛАХ

3.1. Нэр дэвшсэн бүтээлийг Оюуны өмчийн газрын даргын тушаалаар тухайн жилд байгуулагдсан ажлын хэсэг сонгон шалгаруулах бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Оюуны өмчийн газрын дарга ажиллана.

3.2. Сонгон шалгаруулах ажлын хэсгийг нэр дэвшиж буй бүтээлийн онцлогоос хамааран доорх төлөөллөөс сонгон 7-9 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

3.2.1 Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл;

3.2.2. Оюуны өмчийн газрын төлөөлөл;

3.2.3.Инновацийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл;

3.2.4. Үндэсний хөгжлийн газрын төлөөлөл;

3.2.5. Шинжлэх ухааны академийн төлөөлөл;

3.2.6. Соёл урлагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл;

3.2.6.Шинжлэх ухаан технологийн сангийн төлөөлөл;

3.2.7. Шилдэг зохион бүтээгчдийн холбооны төлөөлөл;

3.2.8. Их, дээд сургуулиудын төлөөлөл;

3.2.9. Монголын хөгжмийн зохиолчдын холбооны төлөөлөл;

3.2.11.Монголын урлагийн зөвлөлийн төлөөлөл.

3.3. Оюуны өмчийн шилдэг бүтээл шагналд бүтээлээ нэр дэвшүүлэгчтэй хамаарал бүхий этгээдийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүнээр томилохгүй.

3.4. Оюуны өмчийн шилдэг бүтээл шалгаруулах ажлын хэсэг хуралдааны хэлбэрээр ажиллана. Нийт гишүүдийн 80 хувь оролцсон тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.5. Оюуны өмчийн шилдэг бүтээлд нэр дэвшиж буй бүтээлийн зохион бүтээгч, уран бүтээлч, эзэмшигч хуралдаанд бүтээлээ танилцуулна.

3.6. Оюуны өмчийн шилдэг бүтээлийг энэ журмын 1.3-д заасан шалгуур үзүүлэлтийг үндэслэн ажлын хэсгийн гишүүн тус бүр үнэлгээ өгч шалгаруулна.

3.7. Ажлын хэсгийн гишүүд шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн тухайн бүтээл тус бүр 1-10 хүртэлх үнэлгээг нууцаар өгнө. /Хавсралт маягт-1/

3.8. Ажлын хэсгийн гишүүдийн өгсөн оноог нэгтгэн дүгнэж, Хавсралт 2-д дурдсан маягтын дагуу онооны нийлбэрээр тухайн бүтээлийн эцсийн үнэлгээг гаргана.

3.9. Оюуны өмчийн газар сонгон шалгаруулсан бүтээлийн талаар холбогдох саналыг боловсруулж, өндөр үнэлгээ авсан эхний гурав хүртэлх бүтээлийг тодорхойлон Оюуны өмчийн үндэсний зөвлөлд хүргүүлж ажлын хэсгийн ахлагч танилцуулна.

ДӨРӨВ. “ОЮУНЫ ӨМЧИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛ” ШАГНАЛААР ШАГНАХ

4.1. Монгол Улсын Ерөнхий Сайд Оюуны өмчийн үндэсний зөвлөлийн дарга шийдвэр гаргаж шалгарсан бүтээлийг “Оюуны өмчийн шилдэг бүтээл” шагналаар шагнана.

4.2. “Оюуны өмчийн шилдэг бүтээл” шагналыг Оюуны өмчийг эрхийг хамгаалах өдөр гардуулна.

4.3. “Оюуны өмчийн шилдэг бүтээл “ шагналаар шагнагдах иргэн, хуулийн этгээдийг “Оюуны өмчийг хамгаалах өдөр” - өөс өмнө 10 хоногийн дотор олон нийтэд зарлана.

4.4. Иргэн, хуулийн этгээд тухайн өдөр хүрэлцэн ирэх боломжгүй бол түүний хүрэлцэн ирсэн өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Төрийн ёслол, хүндэтгэлийн өргөөнд ёслол төгөлдөр гардуулна.

4.5. “Оюуны өмчийн шилдэг бүтээл” шагнал, дагалдах батламж, урамшууллыг гардуулах ёслолын ажиллагаа /цаашид ёслолын ажиллагаа гэх/-г Монгол улсын засгийн газар Төрийн ёслолын албатай хамтран Төрийн ёслол, хүндэтгэлийн танхим /цаашид танхим гэх/-д зохион байгуулна.

4.5. “Оюуны өмчийн шилдэг бүтээл шагнал ” хүртсэн эрх эзэмшигчид Медалион, гэрчилгээ, мөнгөн шагнал олгоно.

4.6.“Оюуны өмчийн шилдэг бүтээл шагнал”-д зарцуулах зардлын төсвийг Оюуны өмчийн газрын саналыг үндэслэн Оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад суулган батална.

--oOo---

Оюуны өмчийн шилдэг бүтээлд дэвшсэн бүтээлд өгөх үнэлгээ

№	Бүтээлийн нэр	Дүгнэх үзүүлэлт					Нийт оноо
		Эрхийн хамгаалалт хийгдсэн эсэх	Төр, нийгэм, үндэстний өмнө онцгой гавьяа байгуулсан	Эдийн засгийн эргэлтэд орж ашиг олсон байдал	Гадаад улсад экспортолсон байдал	Зохиогчийн эрхийн бүтээлийг олон улсад сурталчилан таниулах үйлсэд хувь нэмэр оруулсан байдал	
1.							
2.							
3.							
4.							
5.							
6.							
7.							
8.							
9.							
10.							

Үнэлгээ өгсөн: / /
Гарын үсэг

... он ... сар ... өдөр

ОЮУНЫ ӨМЧИЙН ОНЫ ШИЛДЭГ БҮТЭЭЛД ДЭВШСЭН БҮТЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ
НЭГДСЭН ДҮН

№	Бүтээлийн нэр	Үнэлгээ										Нийт оноо
		1	2	3	4	5	6	7	8	9	10	
1.												
2.												
3.												
4.												
5.												
6.												
7.												
8.												
9.												

Дүнг нэгтгэсэн: Ажлын хэсгийн гишүүн : / /
/ /

... он ... сар ... өдөр